



## ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ДАРГА Н.ТУНГАЛАГ ТАНАА

### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэngийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2024.01.20 № 25  
таний -ны № -т

#### Г Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гучин-ус сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гучин-ус сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгаас 792.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 0.6 сая санхүүжилт хийгдэж тухайн онд 16.6 сая төгрөгийг эргүүлэн төвлөрүүлсэн. Төсвийн гүйцэтгэл 793.0 сая төгрөг буюу 95.4 хувьтай, тайлант онд батлагдсан төсөвт 92785.4 сая төгрөгийн тодотгол хийсэн байна. Төсвийн гүйцэтгэл 38.2 сая төгрөгөөр буюу 4.6 хувь дутуу гүйцэтгэлтэй байгаа нь тухайн онд татварын орлого дутуу бүрдсэнээс шалтгаалан байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр хийгдэх ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэвэр усны шугам, дулааны шугам барих, гүн өрмийн худаг гаргах зэрэг ажил хийгдсэнээр үндсэн хөрөнгө урьд оноос 205.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

015030180

D:\Auditiiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Санхүүгийн тайландаа төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.





## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхэр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2024.01.23 № 28  
таний -ны № -т

### ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ТҮНГАЛАГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасны дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 4.5 сая төгрөгийн бараа материалыг тооцоо бодсон акт үйлдэж баталгаажуулаагүй зерчлийг цаашид давтан гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг хэрэгжкүүлж, тогтоосон хугацаанд хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР О.БАТЖАРГАЛ





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 3264920665/084-2024/18/НА-СН-543 Арвайхээр сум

Г ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн танай байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тооллогоор 4543.3 мянган төгрөгийн бараа материалыг тооцоо бодсон акт үйлдэж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бodoх бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайландаа тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.2-д заасан “хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 01-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гучин-ус сумын Засаг даргын Тамгын газрын дарга Н.Тунгалаг, Нягтлан бодогч Ө.Бадамзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

“ЭЛБЭГБАЯН БУЛАГ” АУДИТ ХХК-ИЙН

АУДИТОР Б.НАРАНТУЯА